

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

(2019 оны жилийн эцсийн байдлаар)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

2020-01-27

Улаанбаатар хот

ЗГҮАХ-т тусгагдсан зорилт (зорилтын дугаар)	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ (арга хэмжээний дугаар)	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2019 оны зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)	
					Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн, хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ОНЦГОЙ БОДЛОГО						
Тэргүүлэх зорилт № 1. Эдийн засагт үүссэн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, макро эдийн засгийн тэнцвэрийг хангах, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, түүхий эдийн үнээс хэт хамааралтай байдлыг бууруулж, төлбөрийн тэнцлийн эрсдэлийг багасгах, дунд хугацаанд учирч байгаа өрийн дарамтыг бууруулах, эдийн засгийг дархлаатай болгох, улмаар эдийн засаг дунд хугацаанд тогтвортой тэлэх бодлогыг баримтална.						
1.4. Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг танах, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулна.	5.Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын дүнгийн мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах	2016-2020	ТӨБЗГ	-	Үзлэг, тооллогын мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилтийг хангах	<p>ТӨБХХ</p> <p>2016 оны улсын тооллогын мөрөөр авах арга хэмжээний хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв:</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн 6012 хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрх болон үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний үр дүнг хүлээн авч, улсын нэгдсэн дүнг нэгтгэсэн. Үнэлгээний нэгдсэн дүн, дүгнэлт, үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, шийдвэрийн төслийг ТӨБЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанд танилцуулан дүнг баталгаажуулж, авах арга хэмжээг тогтов. ТӨБЗГ-ын хуралдааны 20 дугаар тэмдэглэлээр төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрх болон үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар тогтож, Засгийн газрын “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын төсөл, танилцуулгыг 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А-1/3539 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>Үнэлгээний нэгдсэн дүнгийн тойм: Төрийн болон орон нутгийн өмчит 6012 хуулийн этгээдийн 79445 ширхэг барилга, байгууламж байгаагаас төрийн өмчийн 20211 ширхэг барилга, байгууламж 7,773.1 тэрбум, орон нутгийн өмчийн 59234</p>

					<p>ширхэг барилга багууламж 5,120.5 тэрбум төгрөгөөр тус тус үнэлэгдэж санхүүгийн тайланд тусгагдсан. Дахин үнэлгээгээр барилга байгууламжийн үнэлгээний дүн 4,640.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байна. Үнэлгээнд 12676 нэгж талбарын 45,465.3 га газрыг өмчлөх, эзэмших, ашиглах эрх хамрагдаж, 3,591.2 тэрбум төгрөгөөр бүртгэгдсэн. Монгол Улсаас Гадаад улсад суугаа 23 Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшилд байгаа 33 нэгж талбарын 99,999.9 м.кв талбай бүхий газар өмчлөх, эзэмших эрх 22.5 сая ам.доллараар, 69.5 сая ам.долларын 214 барилга байгууламж дахин үнэлэгдэж, 133.6 сая ам.доллараар санхүүгийн тайланд тусгагдсан.</p> <p>Үндсэн хөрөнгийн дансны ангилал цэгцлээгүй хөрөнгийн жагсаалт гарган залруулах ажлыг зохион байгуулж, 2019 оны жилийн эцсийн тайланд тусгуулсан.</p> <p>Тооллогоор илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, хэрэгцээнээс илүүдэлтэй болон цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийг данснаас хасах, маргаантай хөрөнгийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх талаар Орон нутгийн өмчийн газруудтай хамтран ажилласан.</p> <p>ХЗДХ-ийн сайдын 2019 оны А/41 дүгээр тушаалаар байгуулагдсан “Төрийн болон албаны нууцын тухай хуульд зааснаас бусад төрийн өмчийн эд хөрөнгийн эрхийг улсын бүртгэлд бүртгэх журам”-ын төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт тус байгууллагын төлөөлөл ажиллаж, холбогдох санал дүгнэлт гарган журмын төсөлд тусгах асуудлыг тодорхойлон ажилласан.</p> <p>ТБОНӨТХуулийн дагуу 2020 онд зохион байгуулагдах төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын зардлын төсвийг боловсруулан, улсын төсөвт тусгуулах арга хэмжээг авсан.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Үр дүнтэй” – 100%</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, тухайн жилийн зорилтот түвшинд хүрсэн. Удирдлага, зохион байгуулалт сайн, үр дүн гарсан.</p>	
	6.Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалт, санхүү, эдийн засгийн байдалд	2016-2020	ТӨБЗГ	19.2 улсын төсвийн эх үүсвэр, Хяналт шалгалтын	39 байгуулла-гад шалгалт хийх, хуулийн хэрэгжилтийг хангах	<p>ТӨБХХ</p> <p>2019 онд төрийн өмчийн оролцоотой 5 компани, төрийн өмчит 19 компани, төрийн өмчит 4 үйлдвэрийн газрын үндсэн болон санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр төлөвлөгөө, хуваарийг ТӨБЗГ-ын 2019 оны 12 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллав. Тайлант жилд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 32 хуулийн этгээдийн удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийснээс 6 хуулийн этгээдэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар нийт 49.7 тэрбум төгрөгийн зөрчил, дутагдлыг илрүүлсэн байна. Зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч, үр дүнг тайлагнан мэдээлэх талаар холбогдох хуулийн этгээдэд ТӨБЗГ-ын тогтоол, холбогдох албан бичгээр нийт 202 үүрэг, чиглэл, зөвлөмж өгч,</p>

	баримтын шалгалт хийж, төлбөр зөрчлийг барагдуулж, төсвийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх			ажлыг гүйцэтгэх томилолтын зардалд зарцуулсан.	<p>биелэлтийг хангуулах арга хэмжээ авсан.</p> <p>Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны 42 дугаар тэмдэглэлийн 2 дахь заалтын хэрэгжилтийг хангах үүднээс хяналт шалгалтын тайлан болон илэрсэн нийт зөрчлийн эрх зүйн үндэслэл, тэдгээрийг давтан гаргахгүй байх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэнд А-1/806, Барилга, хот байгуулалтын яамны сайд Х.Баделханд А-1/1622, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгд А-1/1623, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгаланд А-2/1898, А-2/1899 дугаартай албан бичгийг тус тус хүргүүлсэн.</p> <p>Сангийн сайдын 2019 оны 54 дүгээр тушаалын дагуу “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн 2016-2019 оны үйл ажиллагаанд санхүүгийн иж бүрэн шалгалт хийх хамтарсан ажлын хэсэгт ажиллаж, холбогдох тайланг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогтод А-1/1254 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэх томилолтын зардалд нийт 19.2 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Үр дүнтэй” – 100 %</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрсэн гэж үзэх боломжтой. 2019 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг ЗГҮАХХАХТ-ний 2019 оны зорилтот түшингээс доогуур (дутуу) баталсан байна. Тухайн жилийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө бүрэн биелсэн.</p>
	7.Төсөвт байгууллагын эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалтын байдал зорилтот болон хэсэгчилсэн мониторинг хийж, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах	2017-2020	ТӨБЗГ	11.2 Улсын төсвийн эх үүсвэр, Төрийн өмчид бүртгэлээр тавих хяналт, мониторингийн ажилд зарцуулсан.	<p>ТӨБХХ</p> <p>Монгол улсын их сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль, Соёл урлагийн их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль, Улаанбаатарын их сургууль, Монгол Улсын Боловсролын их сургууль, Анагаах ухааны үндэсний их сургууль зэрэг 8 их сургуулийн төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалт, газар эзэмших ашиглах эрх, төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээс, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн байдалд 2018 онд хийсэн мониторингийн дүнг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлэв. Шалгалтын дүнд, ТБОНӨТХуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтын дагуу үндсэн хөрөнгө олж авахдаа ТӨБЗГ-т саналаа тавин шийдвэрлүүлж байх шаардлагыг хангуулав. Их, дээд сургуулиас ирүүлсэн саналыг судалж, ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн нийт 57.2 тэрбум төгрөгийн хөрөнгө олж авах зөвшөөрөл олгож, шалгалтад хамрагдсан байгууллагууд 2019 онд зөрчлийг давтан гаргахгүй байхаар болсон. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх талаар чиглэл, зөвлөмж өгч, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд</p>

					<p>хяналт тавьж ажиллав. Өгсөн үүрэг, чиглэл бүхий тогтоол шийдвэрийн биелэлтийг гаргуулан цахим мэдээллийн сан үүсгэв.</p> <p>Төрийн өөрийн өмчийн байр талбайн түрээсийн байдалд мониторинг хийж, төрийн өмчийн ашиглалт, захиран зарцуулалтад хяналт тавин илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авав. Үүнд: төрийн өмчит 9 хуулийн этгээд, түүний салбар нэгжийг хамруулан нийт 32 хуулийн этгээдийн төрийн өөрийн өмчийн байр талбайн ашиглалтын байдалд мониторинг хийв. Мониторингийн дүнгээр, нийт 52 байр талбайг бусдад түрээслүүлсэн боловч ТӨБЗГ-тай хууль тогтоомж, журмын дагуу түрээсийн гэрээ байгуулаагүй, улсын төсөвт төвлөрүүлбэл зохих түрээсийн орлогыг төвлөрүүлээгүй байгаа зөрчлийг илрүүлсэн. Мониторингийн дүнгийн мөрөөр авах арга хэмжээг тодорхой болгох асуудлыг боловсруулж, зөрчил гаргасан хуулийн этгээдэд чиглэл, үүрэг даалгавар өгч ажиллав. Мөн иргэн, хуулийн этгээдэд түрээслүүлж байгаа төрийн өмчийн байр талбайг хэмжиж, зөрүүг тооцон шинэчлэн баталгаажуулах ажлыг зохион байгуулав. Тухайлбал, “МИАТ” ТӨХК-ийн 5, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 1, Багшийн хөгжлийн ордны 2, Засгийн газрын автобаазын 5, Дотоод хэргийн их сургуулийн 5, Улсын 1 дүгээр эмнэлгийн 45, Чингис хаан Олон улсын нисэх буудлын 103, нийт 7 хуулийн этгээдийн бусдад түрээслүүлж байгаа 166 байр талбайн хэмжээний зөрүүг баталгаажуулж, холбогдох зөрчлийг арилгуулах арга хэмжээ авав.</p> <p>Төрийн өмчид бүртгэлээр тавих хяналт, мониторингийн ажилд нийт 11.2 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Тодорхой үр дүнд хүрсэн” – 70%</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрээгүй ч тодорхой ажил, арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн гэж үзэх боломжтой.</p>
--	--	--	--	--	---

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО

Тэргүүлэх зорилт № 2.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг хангах зорилгоор “ЭРҮҮЛ ХҮНС-ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” үндэсний хөтөлбөр, “ҮЙЛДВЭРЖИЛТИЙН 21:100” хөтөлбөр, “ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ” хөтөлбөр, “МАХ, СҮҮНИЙ АНХДУГААР АЯН”-ыг шинээр эхлүүлж, “АТРЫН-III АЯН”-ыг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.

2.58. Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах бараа, түүхий эдийн нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, үйл	1.Хөдөө аж ахуй болон үйлдвэрлэл, үйлчилгээний хоршоодын бэлтгэсэн малын гаралтай түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр	2017-2020	ХХААХҮЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)	200.0	10 хоршоог биржийн арилжаанд оролцуулах	<p>БТУХ</p> <p>Хөдөө аж ахуйн бирж нь Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын “Ишгэн хэдмэг”, Дорноговь аймгийн Алтан ширээ сумын “Олон ширээ”, Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын “Сүлэн дэнж”, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын “Тунгалаг уст шураг”, Булган аймгийн Орхон сумын “Орхон эсгий” хоршоодод байнгын бус гишүүний эрх олгон, дээрх хоршоод биржийн арилжаанд шууд оролцох боломжтой болсон. Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах бараа, түүхий эдийн нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр боловсруулаагүй адууны ширийг биржийн</p>
--	---	-----------	---	-------	---	---

ажиллагааг боловсронгуй болгоно.	арилжих ажлыг эрчимжүүлэх					<p>арилжаагаар арилжих шийдвэр гарч хэрэгжиж байна.</p> <p>“Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2018 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн А/19 дугаартай тушаал, Засгийн Газрын 2019 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 191 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд “Их зам транс” ХХК, “Улаанбаатар мах экспо” ХХК-д агуулахын итгэмжлэл олгож, туршилтын арилжааг эхлүүлсэн. 2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын шийдвэрийн дагуу 644400 ширхэг монголын үйлдвэрлэлд стандартын шаардлага хангаагүй, боловсруулаагүй адууны ширийг биржийн арилжаагаар арилжиж, экспортлосон. Мөн биржээр арилжаалах бараа, түүхий эдийн нэр төрлийг нэмэгдүүлэхээр ХХААХҮСайдын 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А-409 дүгээр тушаал гарч, 2020 онд мах (дулааны аргаар боловсруулсан хонь, ямаа, үхэр, адууны мах), арьс шир (хонь, ямаа, үхэр адууны боловсруулсан)-ийг тус тус биржээр арилжаалан экспортлохоор шийдвэрлэсэн.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Үр дүнтэй” – 100 %</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрч, тодорхой үр дүн гарсан.</p>
Тэргүүлэх зорилт № 2.3. Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, олон улсын эрдсийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.						
2.70. Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна.	1.Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нэгж байгуулах, үйлдвэрийн дэд бүтцийн нарийвчилсан судалгаа, үйлдвэр болон дамжуулах хоолойн газрын асуудлыг шийдвэрлэх	2016-2017	УУХҮЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)	-	-	<p>БТУХ</p> <p>Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн өмчит компани байгуулах талаар 2017 оны 03 сарын 20-ны өдрийн Засгийн газрын 92 дугаар тогтоол гарч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 04 сарын 04-ний өдрийн 108 дугаар тогтоолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” 100 хувь төрийн өмчит ХХК байгуулсан.</p> <p>Төслийн нарийвчилсан техник эдийн засгийн үндэслэл (НТЭЗҮ)-ийг Энэтхэгийн “Инженерс Индиа Лимитэд” компани гүйцэтгэж, 2018 оны 11 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд УУХҮЯ-ны Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар баталсан.</p> <p>Мөн Төслийн менежментийн зөвлөхөөр “Инженерс Индиа Лимитэд” компанийг сонгон шалгаруулж, 2019 оны 05 сарын 13-ны өдөр Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан. Улмаар Төслийн менежментийн зөвлөх төслийн дараагийн үе шатны ажлууд болох үйлдвэрийн суурь инженерчлэлийн зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлээд байна. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн лиценз эзэмшигчдийг сонгон шалгаруулах, төслийн өмнөх үе шатны барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх Гэрээлэгчийг сонгон шалгаруулах ажлыг Энэтхэгийн Экспорт-Импортын банкттай</p>

					<p>хамтран зохион байгуулж байна.</p> <p>Үйлдвэрийн барилга угсралтын ажлыг эхлүүлэхэд шаардагдах дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд төлөвлөгөөний дагуу амжилттай хэрэгжиж байна. Тухайлбал, Сайншанд сумаас үйлдвэрийн байршил хүртэлх 17.5 км хүнд даацын тусгай зориулалтын асфальт, бетон хучилттай авто замын барилгын ажил 50 гаруй хувьтай, 27 км салбар төмөр замын барилга угсралтын ажил дуусч, улсын комисс ажиллахаар бэлтгэж байгаа, цахилгаан дамжуулах агаарын шугам болон дэд станцын барилгын ажил бүрэн дуусч, техникийн комисс болон улсын хүлээн авсан.</p> <p>Үйлдвэр байгуулахад зориулж Алтанширээ сумын нутагт нийт 400 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан. Тус газарт үйлдвэрийн барилга угсралтын ажлыг эхлүүлэхээс өмнө талбайн тэгшилгээ, газар шороо болон хашаа барих ажлыг Барилга, хот байгуулалтын яам хариуцаж, Төслийн менежментийн зөвлөх компаниас үйлдвэрийн төлөвлөлтийг хүлээн авч, талбайн ажлыг эхлүүлсэн.</p> <p>Уул, уурхай хүнд үйлдвэрийн яамнаас дамжуулах хоолойн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх талаар санал боловсруулан Энэтхэг, Герман, Итали түншүүдтэй холбоо тогтоож, ойрын хугацаанд санхүүжилтийг шийдвэрлэхээр ажиллаж байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Үр дүнтэй” – 100 %</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрч байгаа, үр дүнг гарсан.</p>
	2.Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээний талаар санал боловсруулах, холбогдох шийдвэрийг гаргуулах, төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах бэлтгэлийг хангах	2017	УУХҮЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)	-	<p>БТУХ</p> <p>“Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл”-ийг БНЭУ-аас олгосон 1.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд санхүүжүүлж байгаа болно. “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн үйл ажиллагаа болон үйлдвэрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлуудыг Хөгжлийн банкнаас олгосон 250.0 тэрбум төгрөгийн зээлийн шугамаар санхүүжүүлж байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 323 дугаар тогтоолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамыг тогтоосон.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Үр дүнтэй” – 100%</p> <p>Тэмдэглэл: Засгийн газар, ТӨБЗГ-аас холбогдох шийдвэрийг гаргаж, шаардлагатай арга хэмжээ авсан. Зорилт, арга хэмжээг 2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2018 онд бүрэн хэрэгжсэн.</p>

Тэргүүлэх зорилт № 2.5. Улс орны эдийн засгийн аюулгүй байдлын үндэс болсон эрчим хүчний тогтвортой, найдвартай ажиллагааг бүрэн хангаж, экспортын чадамжтай болох нөхцөлийг бүрдүүлнэ.						
2.97. Улс орны эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн үндэс болсон суурь салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөх, шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ. /Чойбалсангийн ДЦС, Улаанбаатарын Гуравдугаар ДЦС/	1. Дарханы ДЦС-ыг 35 МВт-аар өргөтгөх	2016-2018	ЭХЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)	-	-	<p>БТУХ</p> <p>Дарханы ДЦС-ыг 35 МВт-аар өргөтгөх төслийн ажлын явцын талаар тус компанийн ТУЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн тулгамдаж буй асуудлаар төслийн багт үүрэг даалгавар өгч хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Үндсэн тоноглолын угсралтын ажил бүрэн хийгдэж дууссан. Нарийн хэмжүүрийн тоног төхөөрөмжүүдийн угсралт суурилуулалт холболтын ажлын гүйцэтгэл 98%-тай байна. Цахилгааны холболтын ажлууд бүрэн хийгдсэн. Диспетчерийн үндэсний төвөөс өгсөн тавилын дагуу трансформатор, генераторын хамгаалалтуудын зургийг шинэчлэн холболтын ажлыг бүрэн хийж дуусгасан. Төслийн ажлыг хүлээлгэн өгөх техникийн комисс, Улсын комисс ажилласан. Дарханы ДЦС-ыг 35 МВт-аар өргөтгөх төслийн ажил бүрэн дуусч, ашиглалтад хүлээн авсан бөгөөд хэвийн ажиллаж байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Үр дүнтэй” – 100%</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн. Улсын комисст хүлээлгэн өгч, үйл ажиллагаа нь хэвийн байгаа.</p>
	2. Эрдэнэтийн ДЦС-ыг 35 МВт-аар өргөтгөх	2017-2018	ЭХЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)	-	Ашиглалтад орох	<p>БТУХ</p> <p>Өргөтгөлийн ажил хийхэд оролцох 300 ажилтны квот Засгийн газрын шийдвэрээр батлагдсан. Өргөтгөлийн ажлыг гүйцэтгэх ажилчид байрлах байр болон конторын барилга баригдаж, ашиглалтад орсон.</p> <p>ЭХЯ, “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын төлөөлөл газар дээр нь ажиллан өргөтгөл хийх ажилтай танилцаж, хяналт тавин ажилласан. Үндсэн турбин, цахилгаан трансформаторын үйлдвэрлэл, химийн ус цэвэрлэх төхөөрөмж, бусад үндсэн болон туслах тоноглолуудын үйлдвэрлэл хэвийн явагдаж байна. БНХАУ-ын Хунан компанийн зургийн болон инженер техникийн ажилчид Эрдэнэтийн дулааны цахилгаан станцид ажиллаж байна. Станцын хүчин чадлыг өргөтгөх, шинэчлэх ажил графикийн дагуу үргэлжилж байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Тодорхой үр дүнд хүрсэн” – 70%</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ 2019 оны зорилтот түвшинд хүрээгүй, хугацааны зорилтот түвшин хоцорч байгаа. Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажил үргэлжилж байна. Эхний хагас жилийн тайлангаар тоноглолуудын үйлдвэрлэлийн ажил 80.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнаж байсан. ТӨБЗГ-т шууд хамаарахгүй.</p>

	3.Чойбалсангийн ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх	2018-2020	ЭХЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)	-	Барилга угсралтын ажил эхлэх	<p>БТУХ</p> <p>Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 345 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу “Чойбалсангийн ДЦС-ын 50 МВт-р өргөтгөх” нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулсан. Үнэлгээний хорооны 2019 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн дүгнэлтээр ТВЕА со.ltd компани хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгарсан. Төслийн нэгжийг байгуулан ажиллуулж байна. Станцын өргөтгөл, шинэчлэлийн ажил графикайн дагуу явагдах ажлыг эхлүүлсэн байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Эрчимжүүлэх шаардлагатай” – 40%</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, хугацааны зорилтот түвшин хоцорч байгаа. Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн. 2019 оны жилийн эцсийн энэ тайлан хүртэлх хугацаанд “Үнэлэх боломжгүй” байсан. ТӨБЗГ-ын үйл ажиллагаанаас хэрэгжилт нь шууд хамаарахгүй байна.</p>
	4.Гуравдугаар ДЦС-ыг 250 МВт-аар өргөтгөх	2018-2020	ЭХЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)	-	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 50 хувиас доошгүй байх	<p>БТУХ</p> <p>Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 01-р сарын 03-ны өдөрийн 01 дугаартай тогтоол, 2018 оны 10-р сарын 24-ний өдрийн 325 дугаартай тогтоолоор Улаанбаатар хотын дулааны 3-р цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 250 МВт-аар өргөтгөхөөр шийдвэрлэсэн. Энэ ажлын хүрээнд дараах ажлуудыг хийсэн:</p> <p>“Дулааны цахилгаан станц-3” ТӨХК-ийн зүгээс ОХУ-ын “ИНТЕР РАО” компанитай хамтран ажиллаж, төслийн урьдчилсан судалгаа, хөрөнгө оруулалтын тооцоог хийлгэсэн. “ИНТЕР РАО” компаниас 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн ЭКС/СМ/445 дугаар албан бичгээр хэт өндөр үнийн санал ирүүлсэн. Иймээс, төслийн хэрэгжилтийн хугацаа хүлээж буй хугацаанаас жилээр хойшилж байгаагаас гадна өмнө нь боловсруулсан ижил хэмжээний өргөтгөлийн саналаас 2 дахин их үнэтэй байгаа тухай Эрчим хүчний сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн а/4640 дугаар албан бичгийг “Интер РАО Экспорт” ХХК-д ГХЯ-аар дамжуулан хүргүүлсэн.</p> <p>Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ОХУ-ын “Интер РАО Экспорт” ХХК-ийн төлөөлөгчтэй 2019 оны 03 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд хэлцэл хийсэн. Уг хэлцэлд техникийн асуудал хэлэлцсэн ба 52 сард багтаан барих саналыг 42 сард багтаан барихаар тохиролцсон.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Үнэлэх боломжгүй”</p>

						Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, хугацааны зорилтот түвшин хоцорч байгаа. Хөрөнгө оруулалтын санал (үнийн дүн) харьцангуй өндөр байгаа тул бууруулах асуудлаар тохиролцоо шаардлага байгаа тул энэ талаар санал хүргүүлсэн. Үндсэн хэрэгжүүлэгч нь ЭХЯам бөгөөд ТӨБЗГ-ын үйл ажиллагаанаас хэрэгжилт нь шууд хамаарахгүй байна.
ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГО						
Тэргүүлэх зорилт № 3.1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг боловсруулж, хүн амыг аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх эдийн засгийн тооцооллыг бий болгож, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлнэ. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадал, хандлагад төлөвшүүлж нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн тусламж үйлчилгээг эрс сайжруулах, Халдварт бус өвчнөөс сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого төлөвлөлтөд урт болон дунд хугацааны хөтөлбөр боловсруулж, чанар хүртээмжийг дээшлүүлнэ. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг хангаж, нийгмийн хамгааллыг сайжруулна. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанартай уялдсан эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгоно.						
3.1.4. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг үе шаттайгаар 2 дахин нэмэгдүүлнэ.	10. Эрүүл мэндийн салбарын дэд бүтэц, тоног төхөөрөмжийн байдалд үнэлгээ хийж, хөрөнгө төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх	2017-2020	ЭМЯ (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)	-	Эрүүл мэндийн салбарын төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх	ТӨБХХ Эрүүл мэндийн яамны шууд хамаарах зорилт, арга хэмжээ. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хамааралгүй заалт. Өөрийн үнэлгээ: “Үнэлэх боломжгүй” Тэмдэглэл: ТӨБЗГ-т хамаарахгүй байна. 2017 оны жилийн эцсийн тайланг ТӨБЗГ-ын Даргын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхэд “Үнэлэх боломжгүй” тул цаашид хяналтаас хасуулах санал, шийдвэр гарсан. 2018 оны жилийн эцсийн тайланг Даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх үеэр энэ зорилт, арга хэмжээг ТӨБЗГ-т “Үнэлэх боломжгүй” гэж дүгнэж байгаа болон ингэж дүгнэх боломжтой эсэх талаар ЗГХЭГ-ын ХШҮДАГ-т чиглэл хүсэх, ТӨБЗГ-т хамаарахгүй байгаа тухай тайлбар хүргүүлэхээр шийдвэрлэсний дагуу ТӨБЗГ-ын 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А-1/154 дугаартай “Чиглэл хүсэх тухай” албан бичгийг хүргүүлсэн болно.
Тэргүүлэх зорилт № 3.2.2. Шинжлэх ухааны удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн системийг нэвтрүүлж, мэдлэгт суурилсан инноваци, технологи, үйлдвэрлэлийг хөгжүүлж, шинжлэх ухааны үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ.						
3.2.33. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга,	10. Уул уурхай, шинжлэх ухааны чиглэлд бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд Шинжлэх ухаан, танин мэдэхүйн	2018	ЦЭКАА (ТӨБЗГ хамтран хэрэгжүүлэгч)	-	Шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдээллийн төвийн үйл ажиллагааг эхлүүлэх	ТӨБХХ Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторын орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгох, уул уурхай, шинжлэх ухааны чиглэлд бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд Шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдээллийн төв байгуулах барилга, байгууламжтай холбоотой асуудлаар Цөмийн энергийн комиссын Ажлын алба, бусад холбогдох байгууллагаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хандаагүй болно.

байгууламж, лабораторын орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгохыг дэмжинэ.	мэдээллийн төв байгуулах барилга, байгууламжийн асуудлыг шийдвэрлэх					<p>Нэмэлт мэдээлэл: Холбогдох байгууллагаас 2018 онд 200.0 сая төгрөгийн төсвийн санал өгсөн боловч 2019 оны улсын төсөв, хөрөнгө оруулалтын төсөв, төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдаагүй байна. Тус төвийн барилга байгууламжийн асуудал шийдэгдэх найдвар бага тул танин мэдэхүй, сургалтын зориулалтаар өргөн ашиглаж байгаа Virtual Reality (VR) хэмээх технологийг ашиглах боломжийг хэрэглэхээр төлөвлөж, түүнд шаардлагатай техник хэрэгслийн зардлыг 2020 оны улсын төсөвт тусгуулах, тус төвийг байгуулан ажиллахаар Цөмийн энергийн комиссын Ажлын албанаас өгсөн боловч 2020 оны төсөвт зохих төсөв тусгагдаагүй байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Үнэлэх боломжгүй”</p> <p>Тэмдэглэл: ТӨБЗГ-т одоогоор шууд хамаарахгүй байна. Уг төвийг байгуулах санхүүгийн эх үүсвэр шийдвэрлэгдэж, барилга байгууламжийн асуудал эцэслэсний дараа төрийн өмчид бүртгэх, холбогдох байгууллагаас ТӨБЗГ-т хандах үед ТӨБЗГ-ын чиг үүргийн ажил хийгдэж, тодорхой мэдээлэл бий болох боломжтой гэж үзэв.</p> <p>2018 оны жилийн эцсийн тайланг Даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх үеэр энэ зорилт, арга хэмжээг ТӨБЗГ-т “Үнэлэх боломжгүй” гэж дүгнэж байгаа болон ингэж дүгнэх боломжтой эсэх талаар ЗГХЭГ-ын ХШҮДАГ-т чиглэл хүсэх, ТӨБЗГ-т хамаарахгүй байгаа тухай тайлбар хүргүүлэхээр шийдвэрлэсний дагуу ТӨБЗГ-ын 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А-1/154 дугаартай “Чиглэл хүсэх тухай” албан бичгийг хүргүүлсэн болно.</p>
--	---	--	--	--	--	--

ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Тэргүүлэх зорилт № 5.2. Эдийн засаг, бизнесийн эрх зүйн орчны тогтвортой байдлыг чухалчилж, шаардлагатай өөрчлөлт хийхдээ эрх ашиг нь хөндөгдөх этгээдээс заавал асууж, саналыг нь авах соёлыг хэвшүүлэх зарчмыг баримтална.

5.2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж,	1.Алдагдалтай ажиллаж байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, эдийн засгийн байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх	2016-2020	ТӨБЗГ	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, 12.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийн орлого төвлөрүүлэх	<p>БТУХ</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн менежментийн хариуцлагыг сайжруулах, санхүү, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, үргүй зардал, алдагдлыг бууруулах, улсын төсвийн болон өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалт, хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх, төрийн өмчийн ногдол ашгийг төсөвт бүрэн төвлөрүүлэх, хэмнэлтийн горимд шилжих талаар албан даалгавар, чиглэл өгч, хэрэгжилтэд тухай бүр хяналт тавьж, үр дүнг тооцон ажилласан байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухайн оны зорилтот түвшинг ашигт ажиллагааг дээшлүүлэх, менежментийн хариуцлагыг сайжруулахад чиглүүлэн батлах, биелэлтийг дүгнэхдээ төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн санал, үнэлгээг харгалзан шийдвэрлэсэн.</p>
---	--	-----------	-------	---	---	---

<p>төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана.</p>	<p>арга хэмжээг тодорхойлон, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах</p>					<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйлдвэрлэл, санхүүгийн үр ашгийг 2018 онд дээшлүүлж, алдагдалгүй ажиллах зарчмыг баримтлан хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажилласны үр дүнд дор дурдсан ахиц өөрчлөлт гарсан нь 93 хуулийн этгээдийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн 2019 оны аудитын дүнгээр баталгаажсан. Үүнд: Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 93 хуулийн этгээд 2018 оны жилийн эцсийн дүнгээр 32 их наяд 489 тэрбум төгрөгийн хөрөнгө эзэмшиж, 43830 гаруй ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээр нь нийт 8 их наяд 479 тэрбум төгрөгийн орлого, 1 их наяд 290 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орлого 24.6 хувиар буюу 1 их наяд 676 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 49 хувиар буюу 424.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 82 хуулийн этгээд 2018 онд (2019 оны эхний улиралд аудитаар баталгаажсан) 1 их наяд 531 тэрбум төгрөгийн татвар, хураамжийн орлого, 42.2 тэрбум төрийн өмчийн ногдол ашиг төвлөрүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 33.6 хувиар буюу 385.3 тэрбум төгрөгөөр, ногдол ашиг 3.34 дахин нэмэгдсэн дүнтэй байна ("Эрдэнэс Монгол" ХХК-ийн төлөөлөл хэрэгжүүлдэг 11 компанийн дүн ороогүй болно).</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 6,960.9 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, 5,129.0 тэрбум төгрөгийн зардал гарган 1,346.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан урьдчилсан дүнтэй байна.</p> <p>2019 оны жилийн эцсийн байдлаар 43 хуулийн этгээдээс төрийн өмчийн ногдол ашгийн 155.4 тэрбум төгрөгийн орлогыг Улсын төсөвт төвлөрүүлсэн. Үүнд: "Ирээдүйн өв сан"-д ашигт малтмал олборолтын лиценз бүхий 2 хуулийн этгээд ("Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Монголросцветмет" ТӨҮГ)-ээс 151.5 тэрбум төгрөгийн, 2018 онд ашигтай ажилласан төрийн өмчит бусад 41 хуулийн этгээдээс улсын төсөвт 4.2 тэрбум төгрөгийн төрийн өмчийн ногдол ашгийн орлого төвлөрүүлэв.</p> <p>Өөрийн үнэлгээ: "Үр дүнтэй" – 100 %</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, 2019 оны зорилтот түвшин болох улсын төсөвт төвлөрүүлсэн төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийн хэмжээ хүрэх түвшингээс 13 дахин өссөн өөрчлөлт бүхий үр дүн гарсан.</p>
	<p>2.Төрийн болон орон нутгийн өмчийн талаар</p>	<p>2016-2020</p>	<p>ТӨБЗГ</p>	<p>-</p>	<p>Компанийн засаглалын зарчмууд</p>	<p>БТУХ, ЗХЗХ</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын</p>

	<p>хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх, компанийн сайн засаглалыг хөгжүүлэх замаар төрийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх</p>				<p>хэрэгжих</p>	<p>төсөл боловсруулах ажлын хэсгийг ТӨБЗГ-ын даргын 2019 оны А/107 дугаар тушаалаар байгуулан ажиллуулж, ЗГХЭГ-ын холбогдох удирдлагуудтай санал солилцон чиглэл авсан. Тус ажлын хэсэг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон үзэл баримтлалын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлага, аргачлалын дагуу боловсруулан холбогдох баримт материалын хамт Ерөнхий сайд болон ЗГХЭГ-ын даргад ТӨБЗГ-ын 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А-1/1252 дугаар албан бичгээр хүргүүлэв.</p> <p>“Төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ыг боловсронгуй болгох төсөл боловсруулж, ТӨБЗГ-ын 2019 оны 260 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулав. Компанийн удирдлагын цалин хөлс, урамшууллын тогтолцоог компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөний биелэлт, ашигт ажиллагаа, улсын төсөвт төвлөрүүлсэн ногдол ашигт тулгуурлан тооцох аргачлалыг уг журмын хавсралтаар тодорхой болгосныг мөрдүүлэх арга хэмжээ авсан. Шинэчлэгдсэн журмын дагуу 21 ТӨҮГ болон 24 ТӨК-ийн захиралтай 2019 оны контрактыг байгуулсан.</p> <p>ТӨБЗГ нь “Азийн сан” Олон улсын байгууллага, “Компанийн засаглалын хөгжлийн төв” ТББ-тай хамтран ажиллах чиглэлээр “Төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах” гурвалсан гэрээг 2019 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр байгуулан хамтын ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлсэн. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах, төрийн өмчит 10 хуулийн этгээдэд (“Шивээ овоо” ХК, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “Монголын төмөр Зам” ТӨХК, “Эрдэнэс-Тавантолгой” ХК, “Монголын цахилгаан холбоо” ХК, “Дулааны цахилгаан станц 4” ТӨХК, “МИАТ” ТӨХК, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Төв АЗЗА” ТӨХК, “Дархан АЗЗА” ТӨХК) компанийн засаглалын үнэлгээ хийж, үнэлгээний тайланг компани тус бүрээр гарган холбогдох зөвлөмжийг өгөх, компанийн засаглалын ахисан түвшний сургалт зохион байгуулах зэрэг ажлыг хамтран гүйцэтгэв. ТӨБЗГ-ын болон төрийн өмчит компаниудын 500 гаруй албан хаагчдыг компанийн засаглалын ахисан түвшний сургалтад хамруулж, гэрчилгээ олгох ажлыг хийсэн.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 6,960.9 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, 5,129.0 тэрбум төгрөгийн зардал гарган 1,346.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан урьдчилсан дүнтэй байна.</p> <p>2019 онд 43 хуулийн этгээдээс төрийн өмчийн ногдол ашгийн 155.4 тэрбум төгрөгийн орлогыг Улсын төсөвт төвлөрүүлсэн. Үүнд: “Ирээдүйн өв сан”-д 2</p>
--	--	--	--	--	-----------------	--

					<p>хуулийн этгээд (“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ)-ээс 151.5 тэрбум төгрөгийн, улсын төсөвт 41 хуулийн этгээдээс 4.2 тэрбум төгрөгийн төрийн өмчийн ногдол ашгийн орлого төвлөрүүлэв.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Үр дүнтэй” – 100%</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн. ТӨХЭ-ийн удирдлага, менежмент, хариуцлага, цалин урамшууллын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэсэн журмыг шинэчлэн мөрдүүлсэн. Компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулж, үр дүн гарч байгаа, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын эдийн засгийн үзүүлэлт хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр өнгөрсөн онтой харьцуулахад тогтвортой байх төлөвтэй байна.</p>
	3.Төрийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, хувьчлах үндсэн чиглэлийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах	2017-2020	ТӨБЗГ	-	<p>БТУХ</p> <p>ТӨБЗГ-аас 2018 онд “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Ерөнхий сайд, Засгийн газарт 2018 оны 03 дугаар сарын 21-нд хүргүүлсэн. Тус төслийг тухайн үед Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд 23 хуулийн этгээдийг бүрэн хувьчлах, 4 хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг бууруулах, нийт 27 хуулийн этгээдийг хувьчлах саналыг Улсын Их Хуралд 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн ЗГ-1/112 дугаар албан бичгээр өргөн барьсан. Улсын Их Хурлаас саналыг хэлэлцээд Эдийн засгийн байнгын хорооны дэргэд дэд ажлын хэсэг байгуулан дахин нарийвчлан судлахыг даалгасан. Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлээр Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийг эгүүлэн татах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасан.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Үнэлэх боломжгүй”</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй. ТӨБЗГ-ын үйл ажиллагаанаас хэрэгжилт нь шууд хамаарахгүй байна.</p>
	4.Төрийн өмчит хуулийн этгээдтэй “Төрийн өмчийг эзэмшүүлэх	2016-2020	ТӨБЗГ	25.0	<p>600.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх</p> <p>ТӨБХХ</p> <p>“Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих журам”-ыг шинэчлэн боловсруулж, ТӨБЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 10-ны</p>

	гэрээ” байгуулж, дүгнэх, төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө, илүүдэлтэй байр талбайг түрээслүүлэн, орлогыг төсөвт төвлөрүүлэх					<p>өдрийн 400 дугаар тогтоолоор батлуулан мөрдүүлж эхэлсэн.</p> <p>Дээрх журмын дагуу “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2018 оны биелэлтийг дүгнэх, 2019 оны гэрээ байгуулах ажлыг бүртгэлийн мэргэжилтнүүд нийслэл, 21 аймагт ажиллаж, гүйцэтгэсэн. Төрийн өмчит нийт 1198 хуулийн этгээдээс 972 нь “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2018 оны хэрэгжилтийг дүгнүүлсэн бөгөөд 967 хуулийн этгээд сайн болон хангалттай, 5 байгууллага хангалтгүй үнэлэгдсэн. Төрийн өмчийн оролцоотой компани, төсөл, сан, хөтөлбөрийн нэгжүүд 206, төрийн өмчлөлд шилжиж ирсэн 42 хуулийн этгээд, нийт 248 байгууллага гэрээ дүгнүүлээгүй (шинээр нэмэгдсэн), орон нутгийн өмчид шилжсэн, хувьчлагдсан 22 байгууллага гэрээ дүгнүүлэх байгууллагын жагсаалтаас хасагдсан байна(904+63+5+206+42-22=1198). Гэрээ дүгнүүлсэн болон шинээр нэмэгдсэн байгууллагуудтай батлагдсан журмын дагуу төрийн өмчийг эзэмшүүлэх 2019 оны гэрээг шинэчлэн байгуулсан. “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2018 оны хэрэгжилтийн нэгдсэн дүн болон гэрээ байгуулах, дүгнэх үеэр гарсан зөрчил дутагдлыг арилгах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлан, дүгнэлтийг ТӨБЗГ-ын 26 дугаар хуралдаанд танилцуулсан. Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэсэн ажлын дүнгээр зөвлөмж боловсруулан төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэхээр бэлтгэж байна.</p> <p>2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 101 хуулийн этгээдийн нийт 12,591.28 м.кв талбайг бусдад түрээслүүлж, 335 төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээ, 99 хуулийн этгээдийн давхардсан тоогоор 613 төрийн өмчийн түрээсийн гэрээний сунгалтыг хийж баталгаажуулсан байна. 2019 оны жилийн эцсийн дүнгээр (давхардсан тоогоор) төрийн өмчит 200 хуулийн этгээдийн байгуулсан 948 түрээсийн гэрээний хэрэгжилтийн үр дүнд 2,384.7 сая төгрөгийн түрээсийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Үр дүнтэй” – 100 %</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрсэн, улсын төсөвт төвлөрүүлсэн байр, талбай түрээслүүлсний орлого зорилтот түвшинтэй харьцуулахад 4 дахин буюу 1,784.7 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна.</p>
	5.Төсөвт байгууллагуудын саналыг үндэслэн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтгүй	2016-2020	ТӨБЗГ	3.2	90.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх	<p>ТӨБХХ</p> <p>2019 онд ТӨБЗГ-ын хуралдааны тогтоолоор төрийн өмчит 137 хуулийн этгээдийн 370 нэрийн 22.61 тэрбум төгрөгийн хөрөнгийг худалдах зөвшөөрлийг олгосноос 2019 оны жилийн эцсийн байдлаар 1,949.0 сая төгрөгийн балансын үнэ бүхий 109 автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсан, сэлбэгээр зарж борлуулсан. Үүний үр дүнд, дуудлага худалдаанаас нийт 248.6 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн дүнтэй байна.</p>

	автомашиньг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдаж, орлого төвлөрүүлэх арга хэмжээ авах					<p>Нээлттэй дуудлагын худалдаанд 3.2 сая төгрөг зарцуулж дуудлагын худалдаанаас орсон орлогоос суутган тооцсон болно.</p> <p>2018, 2019 оны дуудлагын худалдааны тогтоолын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Үр дүнтэй” - 100%</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрсэн, 2019 оны жилийн эцсийн хүрсэн түвшинг зорилтот түвшинтэй харьцуулахад 2.8 дахин өссөн буюу 158.6 сая төгрөгөөр нэмэгдсэн үр дүн гарсан.</p>
	6.Төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа эд хөрөнгийг илүүдэлтэй байгууллагаас дутагдалтай байгууллагад шилжүүлэх замаар хэрэгцээ шаардлагыг хангах зохицуулалт хийх, шаардлага хангахгүй хөрөнгийг акталж устгах, шинээр хөрөнгө худалдан авах асуудлыг оновчтой шийдвэрлэж, зардал хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлэх	2016-2020	ТӨБЗГ	-	Төсвийн зардал буурах	<p>ТӨБХХ</p> <p>2019 онд ТӨБЗГ-ын хуралдааны тогтоол, газрын даргын албан бичгээр нийт 962 (давхардсан тоогоор) хуулийн этгээдийн 52281 нэрийн 1,946.25 тэрбум төгрөгийн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлттэй холбоотой асуудлыг шийдвэрлэж, хэрэгжилтийг хангуулсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 333 байгууллагын 30369 нэрийн 155.67 тэрбум төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хасах; - 330 байгууллагын 4648 нэр төрлийн 145.74 тэрбум төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх; - 137 байгууллагын 370 нэрийн 22.61 тэрбум төгрөгийн хөрөнгийг худалдах зөвшөөрөл олгох тухай; - 113 байгууллагын 16720 нэрийн 1,556.66 тэрбум төгрөгийн хөрөнгийг шинээр бүртгэж авах зөвшөөрөл олгох; - 49 байгууллагад 174 нэрийн 65.57 тэрбум төгрөгийн хөрөнгийг олж авах зөвшөөрөл олгох зэрэг болно. <p>Гарсан шийдвэрийг холбогдох байгууллагад хүргүүлэх, хэрэгжилт, тогтоолын биелэлтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллав.</p> <p>Нийт 145.74 тэрбум төгрөгийн илүүдэлтэй хөрөнгийг балансаас балансад шилжүүлснээр шинээр хөрөнгө худалдан авах зардлыг хэмнэж, энэ хэмжээгээр төсвийн зардал буурсан гэж дүгнэж байна.</p> <p>Мөн 4 байгууллагын 4070 нэрийн 27.33 тэрбум төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох арга хэмжээ авсан.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Үр дүнтэй” – 100 %</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрсэн. Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүн гарсан.</p>

	<p>7.Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, төрийн байгууллагуудын дотоод албан хэрэгцээнд ашиглах автомашины тоо, төрөл, нормативыг тогтоох, хяналт тавих замаар төсвийн зардлыг бууруулах арга хэмжээ авах</p>	2016-2020	ТӨБЗГ	-	Зардал хэмнэгдэх	<p>ТӨБХХ</p> <p>Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 2018 онд төрийн өмчит хуулийн этгээдийн автомашины судалгаа, зардлын судалгааг авч нэгтгэн дээд шатны байгууллагад саналаа боловсруулж хүргүүлсэн. Шийдвэр гараагүй.</p> <p>ЗГХЭГ-аас автомашины тоо төрөл болон зардлын судалгааг шинэчлэн тогтоох чиглэл өгсний дагуу мэдээллийг шинэчлэн авч, дүнг нэгтгэх ажлыг зохион байгуулсан. Нэгтгэсэн дүнгээр, төрийн өмчит 1052 хуулийн этгээдийн 6560 автомашины зардлын судалгаа, мэдээллийг 2018 оны жилийн эцсийн санхүүгийн аудитаар хянагдсан тайлантай тулган баталгаажуулж, нэгтгэсэн.</p> <p>Төрийн өмчит байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ч ашиглалтгүй мөн данснаас хасах шийдвэрийн дагуу Автотээврийн хэрэгслийн бүртгэлээс хасуулаагүй, давхардсан, эзэмшигчийн нэр, хаяг зөрүүтэй байгаа зөрчил илэрсэн тул уг зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулав. Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ дүгнэх, шинэчлэн байгуулах ажлын хүрээнд төрийн өмчит хуулийн этгээдийн автомашиныг газар дээр нь үзэж танилцан тоолж, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-тай хамтран автотээврийн хэрэгслийн мэдээллийн сантай тулгалт, үзлэг хийж, зөрчил арилгах ажлыг гүйцэтгэсэн. 2019 оны санхүүгийн тайлангийн дүнгээр судалгааг дахин шинэчилж, дүнг 2020 онд Засгийн газарт танилцуулахаар төлөвлөөд байна.</p> <p>Засгийн газрын дээр дурдсан тогтоолын дагуу төрийн байгууллагуудын дотоод албан хэрэгцээнд ашиглах автомашины тоо, зардалд хяналт тавьж, хуучин автомашин худалдан авч засварын зардал гаргадаг, моторын багтаамж ихтэй автомашин олж авч шатахуун их зарцуулдаг асуудлыг багасгах зорилгоор шинээр худалдан авах автомашинд тодорхой шалгуур тавьж, зөвшөөрөл олгосноор зардал хэмнэх нөхцлийг бүрдүүлэх бодлого барьж ажилласан.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Эрчимжүүлэх шаардлагатай” – 40%</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зорилтот түвшинд хүргэх талаар удирдлага, зохион байгуулалт, холбогдох байгууллагын уялдаа холбоог сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай. Судалгааны үр дүнгээр холбогдох байгууллагаар тодорхой шийдвэр гаргуулах, нормативыг тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай гэж дүгнэв.</p>
	<p>8.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн мэдээллийн</p>	2016-2020	ТӨБЗГ	50.0 төсвийн хөрөнгийн эх үүсвэрээс	Дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион	<p>ТӨБХХ, МТА</p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийг бүрэн боловсронгуй болгох ажилд шаардлагатай хөрөнгө төсөв батлагдахгүй, шийдвэрлэгдэхгүй байгаагаас бүхэлд нь сайжруулалт хийгдэх боломжгүй байна, хуучин системийг ашиглаж, төрийн өмчийн бүртгэл, мэдээллийг нэгтгэж байна. Уг</p>

	системийг боловсронгуй болгох			байгуулах боломжийг бүрдүүлэх	<p>системд хэсэгчилсэн хөгжүүлэлт хийж, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний мэдээллийг нэмэх программ хангамжийн асуудлыг шийдвэрлэж байна. Энэ ажилд 2019 онд нийт 50.0 сая төгрөгийг зарцуулсан, программыг ашиглалтад хүлээж аваагүй байна.</p> <p>Автомашин нээлттэй дуудлагын худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулах боломжийг бүрдүүлж, цахим программын хөгжүүлэлтийг хийсэн. Дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулах хууль эрх зүйн орчин бүрдээгүйгээс дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулахад ашиглах программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлэх ажил хүлээгдэж байна.</p> <p>Түүнчлэн, төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэх, нэгтгэл тайланг цахимжуулах ажлыг хийж, цахим программ хангамжийг боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлэн ашиглаж байна.</p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийн хэвийн үйл ажиллагааг хангах болон хэрэглэгчдэд зөвлөгөө өгөх ажлыг тогтмол хийсэн. 2019 онд нийт 1129 байгууллагыг зөвлөгөө, тусламжаар хангаж ажилласан.</p> <p>2019 оны 05 дугаар сарын 09-ний өдөр ОБЕГ-ын “Сэргээн засал хөгжлийн төв”-д ОБЕГ-ын харьяа байгууллагуудын 40 гаруй албан хаагчид “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем” болон “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ийн сургалтыг зохион байгуулж, цахим системийн ашиглалтыг нэмэгдүүлэх, чадавхийг дээшлүүлэх арга хэмжээ авав.</p> <p><u>Өөрийн үнэлгээ:</u> “Эрчимжүүлэх шаардлагатай” – 40%</p> <p><u>Тэмдэглэл:</u> Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зорилтот түвшинд хүргэх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай. 2018 онд Сангийн яаманд хүргүүлсэн саналын дагуу хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх тодорхой алхамыг хийх шаардлагатай.</p> <p>2017 онд: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 128 дугаар тогтоолын дагуу төрийн өмчийн эд хөрөнгийн цахим дуудлага худалдаа системийг хөгжүүлэх технологийн чиг хандлагыг судалж, программ хангамжийн архитектур болон өгөгдлийн сангийн загварыг гарган кодчиллыг бэлэн болгосон. Цахим хэлбэрээр дуудлага худалдаа зохион байгуулах зорилго бүхий мэдээллийн системийн хөгжүүлэлтийг хийж эхэлсэн.</p> <p>2018 онд: “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-ийн хөгжүүлэлтийн төлөвлөгөө, ажлын даалгавар, зардлын тооцоо судалгааг хийсний үндсэн дээр системийг шинэчлэн боловсронгуй болгох асуудлаар төсөл боловсруулж, санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр ТӨБЗГ-ын 2018 оны А-1/21 тоот албан бичгийг Сангийн яаманд хүргүүлж байсан. Ингэснээр</p>
--	-------------------------------	--	--	-------------------------------	---

					Хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд чиглэсэн алхам хийсэн, төсөл, тооцоог хийж, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон.
5.2.2. Төсөл, тендерийн шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож “Шилэн тендер шалгаруулалт” бодлого хэрэгжүүлнэ.	1.Худалдан авах ажиллагаанд олон улсын шилдэг арга туршлагыг нэвтрүүлэн, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг боловсронгуй болгож, цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем, дэд системүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх замаар улсын хэмжээнд ашиглалтад бүрэн оруулах	2016-2020	ТӨБЗГ	-	<p>ЗХЗХ, ХААХ, МТА</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль 2019 оны 3 дугаар сард батлагдсан. Төрийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх зүйн зохицуулалт, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд дараах 6 журам 2019 онд шинээр батлагдсан:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам” (Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар); 2. “Тендерт шалгаруулалтын материалын тухайн тендерт оролцогчдод ил болгох журам” (Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар); 3. “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм” (Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоолоор); 4. “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам” (Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоолоор); 5. “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам” (Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар); 6. “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам” (Сангийн сайдын 2019 оны 37 дугаар тушаалаар). <p>Дээрх хууль тогтоомжийн төслийг боловсруулахаар Сангийн яаманд байгуулагдсан ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөлөл ажиллаж, тус байгууллагын байр суурь, саналыг тусгасан болно.</p> <p>Тайлант хугацаанд, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Шведийн вант улсын худалдан авах ажиллагаа, Ерөнхий гэрээ байгуулах ажлын туршлага судлах сургалт, арга хэмжээнд 2 албан хаагчийг хамруулсан.</p> <p>ТӨБЗГ-ын эрхлэн хөтөлж байгаа төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn –д 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар, улсын дүнгээр нийт 17722 тендер шалгаруулалтын урилга зарлагдсан дүнтэй байна. Үүнээс 17384 буюу 98.0 хувь нь “Цахим тендер шалгаруулалт”-ын урилга байна. Цахим тендер шалгаруулалтын урилга өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад, 81.0 хувиар буюу 1.8 дахин нэмэгдсэн нь захиалагч байгууллагууд худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, цахим системийн хэрэглээ нэмэгдсэн, худалдан авах ажиллагааны ил тод байдалд ахиц гарсныг харуулж байна. Улсын хэмжээний уг системийн зарим тоон үзүүлэлтийн үр дүнг</p>

					<p>танилцуулбал, 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> - 2035 захиалагч байгууллагын хэрэгжүүлэх 27010 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө цахим системд бүртгэгдэж, олон нийтэд мэдээлэгдсэн; - тус системээр дамжин нийт 17371 тендер шалгаруулалтын үр дүн олон нийтэд мэдээлэгдсэн байна. Үүнээс: нээлтийн 2528, тендер шалгаруулалтын 14458 үр дүн гарсныг мэдээлсэн бол хянан үзсэн 342, бусад үр дүнгийн 43 төлөв гарсан дүнтэй байна; - бараа, ажил, үйлчилгээний ангиллын системд нийт 27085 бараа, ажил, үйлчилгээ бүртгэлтэй байна; - ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааны үр дүнд тус системийн дэд систем болох “Цахим дэлгүүр”-ээр нийт 2223 удаагийн захиалга хийгдэж, 8.9 тэрбум төгрөгийн 31 нэр төрлийн эм борлуулагдан улсын төсөвт 464.9 сая төгрөгийн хэмнэлт гарсан; - нийт 5077 гэрээ тус цахим системд бүртгэгдсэн байна. <p>Өөрийн үнэлгээ: “Үр дүнтэй” – 100%</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрч, хууль, эрх зүйн орчинд өөрчлөлт орсон, үр дүн гарсан. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн үзүүлэлт 2019 оны мөн үеэс дунджаар 20 хувиар өссөн дүнтэй байна.</p>
	2.Төрийн өмчит хуулийн этгээдийн байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг ерөнхий гэрээ байгуулах замаар хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилтийг	2016-2020	ТӨБЗГ	--	<p>ЗХЗХ, ХААХ, МТА</p> <p>Олон улсын стандартын дагуу барааны каталогийг үүсгэн коджуулах, каталогийн системийн баазыг бүрэн ашиглалтад оруулах</p> <p>“Зарим ерөнхий нэршлийн эмийг ерөнхий гэрээгээр худалдан авах” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулав. Энэ хүрээнд 31 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 15 нийлүүлэгч аж ахуйн нэгжтэй 47 ерөнхий гэрээ байгуулж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn -ийн дэд систем болох “Цахим дэлгүүр”-ээр ерөнхий гэрээний худалдан авалтыг гүйцэтгэв.</p> <p>Мөн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын “Элэгний В, С вирусийн илрүүлэг, шинжилгээнд шаардагдах түргэвчилсэн оношлуурыг худалдан авах ерөнхий гэрээ байгуулах” төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг амжилттай зохион байгуулж, 2019 оны 03 сарын 22-ны өдөр шалгарсан 3 аж ахуйн нэгжтэй ерөнхий гэрээ байгуулж, 2 дахь шатны сонгон шалгаруулалтыг “Цахим дэлгүүр”-ийн системээр гүйцэтгэсэн.</p> <p>2019 онд зохион байгуулсан ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааны үр дүнд “Цахим дэлгүүр”-ээр нийт 2223 удаагийн захиалга хийгдэн 31 нэр төрлийн 8.9</p>

	хангах, мэдээллийн сан бүрдүүлж, баяжуулах					<p>тэрбум төгрөгийн эм, хэрэгсэл худалдан борлуулагдаж, улсын төсвийн урсгал зардалд 464.9 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.</p> <p>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn –ний бараа, ажил, үйлчилгээний ангиллын системийг олон улсын стандарт болох UNSPSC-ын дагуу үүсгэн коджуулж, каталогийн системийн баазыг бүрэн ашиглалтад оруулсан. Уг системд 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 27085 бараа, ажил, үйлчилгээ бүртгэлтэй байгаа нь өмнөх жилийн мөн үеэс 3234-өөр (23851 байсан) буюу 13.5 хувиар нэмэгдсэн байна. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд ХХААХҮЯ-тай хамтран “Монголд үйлдвэрлэв” 2017, 2018 оны дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүний каталогийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn -ийн “Цахим дэлгүүр” хэсэгт байршуулж, худалдан авах ажиллагаанд оролцогч захиалагч, нийлүүлэгчдэд сурталчлан танилцуулав.</p> <p>Өөрийн үнэлгээ: “Үр дүнтэй” – 100 %</p> <p>Тэмдэглэл: Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрсэн, үр дүн гарсан гэж дүгнэх боломжтой, барааны каталогийн системийн баазыг бүрэн ашиглаж байгаа. Каталогид бүртгэлтэй барааны тоо хэмжээ өмнөх оны мөн үеэс 13.5 хувиар нэмэгдсэн дүнтэй байна.</p>
--	---	--	--	--	--	---

ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (ЗГҮАХХАХТ)-нд тусгагдсан арга хэмжээ (заалт) бүрийн хэрэгжилт, үр дүнгээр тайлагнав. Нийт 4 бүлэг бодлогын хүрээний 7 тэргүүлэх зорилтод хамаарах 22 арга хэмжээг ТӨБЗГ-т хяналтад авч, хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргав. Эдгээр 22 арга хэмжээнээс 9 арга хэмжээг нь бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа болно.

Үнэлгээний дүнгийн товч танилцуулга:

ЗГҮАХХАХТ-нд тусгагдсан арга хэмжээ (заалт)-ний тоо – 22; Үүнээс:

- “Үр дүнтэй” буюу 100 % - 13 арга хэмжээ;
- “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 % - 2 арга хэмжээ;
- “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 40 % - 3 арга хэмжээ;
- “Үр дүнгүй” буюу 0 % - 0;
- “Үнэлэх боломжгүй” – 4 арга хэмжээ.

ЗГҮАХХАХТ-ний тухайн жилийн зорилтот түвшингийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ (хувь) – **86.7 % (+2.6%)**.

ТАНИЛЦСАН:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ХЯНАСАН:

ДЭД ДАРГА

А.ДАГВАДОРЖ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН

ДАРГА

А.АРИУНБОЛД

ТАЙЛАНГ НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ